



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 дугаар сарын 29

Дугаар 19/02

Баян-Өндөр сум

Сумын хамгаалалтад байх түүх, соёлын
үл хөдлөх дурсгалын жагсаалт
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.12, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймаг Жаргалант сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Аймгийн нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтыг сайжруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргад даалгасугай.

2.1.Жагсаалтаар баталсан түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хяналт тавих, тэдгээрийг сэргээн засварлахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж хэрэгжилтийг хангах;

2.2.Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэх;

2.3.Сумын хамгаалалтад байх шаардлагатай боловч жагсаалтаар батлагдаагүй түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн батлуулах ажлыг зохион байгуулах.

ДАРГА  Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Ээлжит XIX хуралдааны 19/02 дугаар тогтоолын хавсралт



**ЖАРГАЛАНТ СУМЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ
ГАЗРЫН ЖАГСААЛТ**

№	Дурсгалт газрын нэр	Дурсгалын тоо ширхэг	Солбицлын цэг	
			Уртраг	Өргөрөг
1	Дулаан уул	12	N49 3 41.8	E104 28 51.6
2	Дуулгат уул	2	N49 5 53.6	E104 27 25.6
3	Дэл хад	11	N49 4 53.7	E104 32 20.2
4	Уртын ам	16	N48 57 57.8	E104 26 27.6
5	Чингэлийн гол	121	N48 54 38.1	E104 21 0
6	Панзын далиу		N48 57 50.6	E104 17 30.2
7	Тугалч		N48 58 38.18	E104 17 56.36
8	Богино сайр		N48 57 38.1	E104 17 0
Нийт		162		